



ДАРХАН ХОТЫН СӨҮЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ





ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН ОНӨДӨРҮҮГ

АЛСЫН ХАРАА

Цэцэрлэгт хүрээлэн, соёл амралтын хүрээлэнгийн инновац шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ улсдаа тэргүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Цэвэр тухтай, байгальд ээлтэй бүхий л насныхны хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН ОНӨДӨРҮҮГ нь 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 15 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд орон нутгийн төсвөөс дэмжлэг авах, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан үйл ажиллагаа явуулах аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

МИНИЙ МОНГОЛ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, Дархан 50 цогцолбор, Найрамдал талбай, Морин хуур цогцолбор, Бурхантай толгой цогцолбор, Дүүжин гүүр, Сүрэнгийн гудамж, Залуус цогцолбор гэсэн иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулагдсан цэцэрлэгт хүрээлэн, соёл амралтын хүрээлэнгүүдийн нийтийг хамарсан үйл ажиллагаа болон бусад үйлчилгээг эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан түвшинд үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.



БИДНИЙ УРИА

Сэтгэл, зүтгэл бүтээмжтэйгээр түүхээ бүтээнэ.



2022 оны Дархан
сумын
“ХӨДӨЛМӨРИЙН
АВАРГА
БАЙГУУЛЛАГА”-аар
шалгарч Дархан
сумын ЗДТГ-аас
цомоор
шагнагдсан.

2023 онд
“АЙМГИЙН
ТЭРГҮҮНИЙ
БАЙГУУЛЛАГА”-аар
шагнагдан ажил
хөдөлмөрөөрөө
өндөрөөр
үнэлэгдсэн юм.




2024 оны “Нийгмийн
салбарын тэргүүний
байгууллага”-аар
шалгарч “Мөнгөн
сарнай-2024” цомын
эзэн хамт олон
болсон амжилтаар 3
дахь жилдээ үйл
ажиллагаагаа
явуулж байна.



МИНИЙ МОНГОЛ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН нь 2007 онд Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газрын санаачлагаар 15 ААНБ хамтран нийтийн эзэмшлийн 44 га газрыг сонгон цэцэрлэгт хүрээлэн болгон байгуулсан. Анх 10 хүний бүрэлдэхүүнтэй 8 төрлийн 26,000 ширхэг мод, бут, 12 төрлийн 2100 ширхэг цэцгийн үрсэлгээ, 173 ширхэг гацуур, 1302 ширхэг гэрэлтүүлгийн ажил хийгдэж байсан.

Одоогын байдлаар ногоон байгууламжийн чанар стандартаар улсдаа тэргүүлэн 2023 оны байдлаар нэмж 5 төрлийн 830 гаруй мод бутыг нэмж тариад байна. 2019 онд БНХАУ-аас 7 төрлийн хөдөлгөөнт тоглоомыг Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд суулгаж ашиглалтад оруулсан.



ДАРХАН-50 ЦОГЦОЛБОР нь Дархан хот үүсгэн байгуулагдсан 50 жилийн ойд зориулан 2011 онд Засаг Дарга асан Г.Эрдэнэбат санаачлан улсын төсвийн хөрөнгө оруулалт, иргэдийн хандив тусlamжаар үүсгэн байгуулагдсан. Одоогоор 4,2 га газарт 11 төрлийн 230,000 гаруй мод, бут ургаж 24 цагийн харуул хамгаалалттай 4 цэцэрлэгчтэй үйл ажиллагаа явуулж байна.



МОРИН ХУУР ЦОГЦОЛБОР ГАЗАР нь 2006 онд Хөхөө Намжил домгоос сэдэвлэн хүрэл баримал бүхий цогцолборыг нийтийн эзэмшлийн урагш харсан уулын энгэрт байгуулсан. 8 төрлийн 5000 ширхэг мод бут, 165м² талбайд зүлэгжүүлэлт, 80м² талбайд усалгааны систем, 480 ширхэг цэцэгний үрсэлгээг анх тарьж байсан. 2023 оны байдлаар ногоон байгууламжийн тоо өөрчлөгдөөгүй цэвэрлэгээ үйлчилгээг цаг тухайд нь хийж иргэдийн амарч зугаалах тав тухтай газар болгон хадгалсаар ирсэн.



ДҮҮЖИН ГҮҮР 2008 оны 4 сард эхлүүлэн 2008.07.31-ны өдөр 110 метр урттай, 4 метр өргөнтэй дүүжин гүүрээр Бурхантай толгой, Морин хуур цогцолборыг олон улсын замын дээгүүр холbon 2014 онд Миний Монгол цогцолбор газар луу ордог байхаар шинэ гүүр залгаж холбосон. З чиглэлд холбогдсон тус гүүрийг БНХАУ-ын Лихуа зам гүүр байгууламжийн компани хийж гүйцэтгэсэн.



ХӨЛБӨМБӨГИЙН ТАЛБАЙ 2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж 2022 оны 7 сарын 28-нд ашиглалтад орсон хөлбөмбөгийн талбай нь олон улсын жишигт нийцсэн иж бүрэн талбай юм.



ГЭРЭЛТ ГУДАМЖ Дархан хот байгуулагдсаны 60, 61 жилийн ойн баярыг угтан "Дархан хотын Соёл Амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ын хамт олон "Дархан-Өргөө" политехник коллежийн Гагнуурын 4 дүгээр



курсын багш оюутнуудын төлөөлөл, Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийн Цахилгааны 3 дугаар курсын багш, оюутнуудын төлөөлөлтэй хамтран хамтран ажиллаж, өөрсдийн нөөцөөр "МИНИЙ МОНГОЛ" цэцэрлэгт хүрээлэнд ГЭРЭЛТ ГУДАМЖ-ийг бүтээн байгуулжээ.






**НАЙРАМДАЛ
ТАЛБАЙ** Залуучууд театрын өмнөх цементэн талбай нь 1973 онд Залуучууд театр байгуулагдах үед хийгдэж байсан бүтээн байгуулалт юм.

ЗАЛУУС ЦОГЦОЛБОР

Дархан хот үүсгэн байгуулагдсаны 60, 61 жилийн ойн хүрээнд зориулан бүтээжээ.




БУРХАНТЫН ТОЛГОЙ нь
2008.07.31-нд Бурхан
багшийн сэргэг дүрийг
Морин хуур цогцолборын
урд уулан дээр хослуулан
байгуулж 1,6 га талбайд
тохижилтын ажлыг хийсэн.



СҮРЭНГИЙН ГУДАМЖ
Дархан хотын Дарга асан
Г.Сүрэнгийн дурсгалд зориулан
2.3 га газарт явган хүний чулуун
зам, гэрэлтүүлэг, амралтын саад
бүхий тохижилтийг Алтантариа
ХХК-иас гэр бүлийн хүмүүс
тохижуулан хариуцаж 2011 онд
байгуулсан.







AMUSEMENT PARK OF DARKHAN CITY





976 70376061



dhsahvreelen@gmail.com
www.parkdarkhan.mn



Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14 дүгээр баг
Миний Монгол цэцэрлэгт
хүрээлэн



ДАРХАН ХОТЫН СОЁЛ
АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН



parkdarkhan



parkdarkhan

